

ХРИСТИЙН ШАШНЫ ЦУГЛААН БА ДУУЛАХ ЗАН ҮЙЛ

М.Отгонбаяр (Ph.D)
Ж.Пүрэвдорж (Докторант)
Философи, шашин судлалын тэнхим
ШУС. МУИС

Тулхүүр үсэс: Христийн шашин, цуглаан, цугларалт, дуулах зан үйл, эвхарист, теологи.

ХХ зууны 90-ээд оныг хүртэл социалист системийн орнуудад, түүний дотор БНМАУ-д эрх баригч коммунист намын үзэл суртлын зэвсэг болсон марксизмын үзэл санааны нөлөөгөөр атеист буюу шашингүйн үзэл ноёрхож ирсэн билээ. ХХ зууны 80-аад оны дунд үеэс анх ЗХУ-д хүчээ авч өрнөсөн өөрчлөн байгуулалт, ил тод байдал нь социалист системийн өөрчлөлт, ардчилсан хувьсгалд хүргэсэн. Энэ явцад Монголын нийгмийн оюун санааны амьдралд гарсан нэг том өөрчлөлт бол 1992 онд батлагдсан Монгол улсын үндсэн хуулиар “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” хэмээн тунхагласнаар монгол улсын иргэд шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй болсон билээ.

Үндсэн хуулиар баталгаажсан энэхүү эрх, эрх чөлөөний хүрээнд нэг талаас уламжлалт буюу буддын шашин болон бөө мөргөл сэргэж, нөгөө талаас бусад шашны янз бүрийн үзэл баримтлал, итгэл үнэмшил манай улсад нэвтрэн орж ирсний томоохон хэсэг нь Христийн шашин юм. 2010 оны Монголын Үндэсний Статистикийн хорооноос гаргасан судалгаанд 15 буюу түүнээс дээш насны хүн амын 61.4 хувь нь ямар нэгэн шашинтай хэмээн бүртгэсэн байна.¹ Шашинтай хэмээн бүртгүүлсэн иргэдийн 3.5 хувийг Христитгэлтнүүд эзэлж буй² бөгөөд энэхүү шашны түгэн дэлгэрсэн нөхцөл байдал, сүм чуулган/байгууллагууд/-ы үйл ажиллагаа, итгэгчдийн мөргөл, зан үйл зэргийн тухай судалгаатай мэдлэг, мэдээлэл нэн чухал болоод байгаа билээ.

2018 оны статистикийн мэдээллээр Монголд нийт 196 Христийн шашны сүм чуулган байгаа нь бусад бүх шашны сүм хийдийн тоог нийлүүлснээс даруй 15%-аар илүү байгаа юм. Бүртгэлтэй нийт 196 Христийн сүмд 202, Буддын 134 сүмд 1321 “орон тооны ажилтан” байгаа³ гэсэн статистикийн мэдээлэлд анхаарал хандуулж, анализ хийх шаардлагатай. Энэ тоо Монгол Улс дахь уламжлалт шашны “дээдлэгдэх” байр суурийг бууруулах, мөн “гаднаас” орж ирсэн шашин хэт томорч нийгмийн оюун санаанд буруугаар нөлөөлөх вий гэсэн хардлага сэргэжлийг төрүүлдэг. Тооны энэхүү ялгаатай байдал тэдгээр шашны номлол, теологи, мөргөл, зан үйлийн суурь шинжтэй ялгаанаас үүдэлтэй гэсэн таамаглалыг батлах зорилгыг энэ өгүүлэлдээ тавилаа.

¹ Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, “Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын үр дүн,” хуудас 61.

² Мөн тэнд.

³ https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L20_3&year=2018, accessed April 21, 2019.

Аливаа шашны мөргөл, зан үйл түүний дотор Христийн шашны зан үйл, ялангуяа дуулах зан үйл бусдаас ихээхэн онцлог ялгаатай. Буддын шашин болон бөө мөргөлийн зан үйлд сүсэгтэн олныг дуулах зан үйлд төдийлөн оролцуулдаггүй бол Христийн шашны удирдагчид төдийгүй мөргөлд оролцогч бүх хүмүүс дуулах зан үйлийг гүйцэтгэдэг. Ямар учраас Христийн шашны, ялангуяа протестант урсгалын итгэгчид долоо хоног бүр цуглаж, мөргөлийн зан үйлээ гүйцэтгэхдээ, дуулдаг юм бол?

Мөн цаг хугацааны хувьд Христийн шашин үүссэн эхний гурван зуун (I-III зуун) буюу бүрэлдэн тогтох үеийг хамруулан авч үзсэн болно. Учир нь Христийн шашны эхэн үеийн суурь ухагдахуун өнөөдөр ч чухал хэвээр байгаа юм. Христийн шашин үүсэн бий болсон үеийн баримт материал цөөн, тэдний цугларалт, мөргөл дэх дуулах зан үйлийнх нь тухай онцлон бичсэн материалууд байдаггүй боловч өөр зорилгоор, ялангуяа Христэд итгэх итгэл үнэмшлийг хамгаалах, тайлбарлах, гаж сургаалуудыг няцаах, итгэгчдийг бичвэр болон номлогоор зааварчлах зорилгоор бичигдсэн баримт материалууд дээр дурдсанаас олж болно. Шинэ гэрээ болон патрист (Patristic period–Эцгүүдийн үе) баримтуудаас харвал тэд цугларч, баптисм болон Эзэний Зоогийн (мөн Эвхарист, Ариун Нөхөрлөл – Eucharist, Holy Communion гэж нэрлэдэг) зан үйлийг гүйцэтгэж, мөн ерөөл, магтаал зэргийг өргөж байжээ.

Долоо хоног бүрийн цуглааны тухайд

Христийн шашин бол ХТ I зуунд Иудейн шашнаас салаалан гарсан шашин гэж хэлж болно. Христийн шашны анхны цугларалт нь Иудейн шашны синагогийн (грек. συναγωγή – assembly – цуглаан, цугларалт) цуглах зан үйл дээр үндэслэн бий болжээ. Анхны литург⁴ уулзалт (грек *synaxis*), эвхарист⁵ (грек. *eucharist*) гэсэн хоёр хэсэгтэй бөгөөд эдгээр нь хоёр өөр угшилтай, ялгаатай зүйл юм. Иудейн синагогийн цуглаанаас уулзалт нь гаралтай бөгөөд яваандаа христитгэгчдийн цуглааны үндсэн хэлбэр болсон, харин эвхарист нь Христийнхний хөгжлийн эхэнд бий болсон зан үйл юм (Dix, 1949, p. 36). Христэд итгэгчид анхандаа цугларч синагогийн үйлддэг залбирал, магтаал (praise), ерөөл (blessing), өргөл хандив (offering) зэргийг эвхаристын зан үйлийн хүрээнд үйлддэг болжээ. Өөрөөр хэлбэл, тэдний цуглааны гол зорилго нь эвхаристыг тэмдэглэх зан үйл юм. Энэ бол Есүс Христийн загалмайд цовдлогдон нас барж, дахин амилсныг дурсан үйлдэх ёс дэг гэж хэлж болно. Есүс Христ шавь нартаа захиж хэлсэн үгнээс тэдний цуглааны зан үйлийн үндэс тавигдсан. Есүс иудейн шашны Алгасал баярын⁶ үеэр шавь нартайгаа тэрхүү баярыг тэмдэглэхдээ цаашид хэрхэн тэмдэглэх тухай зааврыг өгсөн (Матай 26:26-30; Марк 14:22-26; Лук 22:14-20; 1Коринт 11:23-25). Энэхүү баяр нь Израилийн ард түмний Миссирээс [өнөөгийн Египет] чөлөөлөгдсөн өнгөрсөн түүхийг дурсан санаж, улмаар ирээдүйд

⁴ Литург (*λειτουργία- liturgy*) гэдэг нь үйлчилгээ, үйлчлэл гэсэн үндсэн утгатай мөргөлийн дэс дараа, тэнд үйлдэгдэж буй зан үйл, дэг жаягийг бүхэлд нь заасан уг юм. Мөн зарим эрдэмтэд литург гэдгийг “олон нийтийн үйлчлэл” гэж томъёолсон байдал. (Nicholas P. Wolterstorff, “Thinking about Church Music” in Kroeker, 2005, p. 9) Литург гэдгээр цуглааны үйл ажиллагааг тэр чигт нь дэг жаяг, зан үйлтэй бүгдийг хамтатган хэлэх нь тун элбэг байдал.

⁵ Эвхарист (*εὐχαριστία - eucharistia*) гэдэг нь талархал өргөх (*thanksgiving*) гэсэн утгатай грек уг юм.

⁶ Hebrew: πόσα Pesaḥ - Passover. Алгасал баяр нь Иудейчүүдийн Египтийн дарлалаас Бурхан чөлөөлснийг тэмдэглэдэг. Ариун Библийн орчуулгад Дээгүүр Өнгөрөх Баяр гэж хэрэглэж байгаад 2013 оны шинэчилсэн хувилбартаа Алгасал гэж өөрчилсөн байдал.

Бурханы аврал *Машияхаар*⁷ дамжин ирэх номлол бүхий баяр юм. Гэтэл Есүс энэхүү зоогийн зан үйлийг тэмдэглэхдээ “намайг дурсан сана” гэсэн чухал тунхаг хэлсэн байдаг. Энэ нь Есүс удахгүй загалмайн үхлийг амсан, хүн төрөлхтний нүглийг үүрэх тэрхүү үйл явдлыг дурсан санах тухай юм гэж эрдэмтэд үздэг. Үүнийг хожим Эвхарист (Eucharist), Эзэний зоог (Lord’s Supper), Ариун Нэгдэл (Holy Communion) гэх зэргээр нэрлэх болсон бөгөөд энэ нь Христийн шашны цугларах ёсны нэр болжээ. Христийн шашин эхний 1000 жилийн түүхэндээ Эвхарист гэдэг нэрийг цуглах үйлийн нэр болгон хэрэглэсэн байдаг бөгөөд Алгасал баярын талх болон дарсыг өргөж, Бурханд талархал өргөдөг угнээс [eucharistia] гаралтай. Есүс шавь нартайгаа сүүлчийн удаа Алгасал баярыг тэмдэглэж заавар өгсөн тэр зан үйлийг Сүүлчийн Зоог хэмээн нэрлэдэг.

Иудейчүүд Ням гарагаас Баасан гараг хүртэл ажиллаж, харин Бямба гарагт буюу долоо хоногийн сүүлийн өдөр амардаг байсан. Бямба гарагт аливаа ажил хийх хориотой бөгөөд зөвхөн Яавэ Бурханд магтаал хүндэтгэл өргөх, Бичвэрээс сонсох, тахилын болон сүмийн зан үйлд оролцох ёстай байжээ.

Зургаан өдрийн туршид ажил хийж болох боловч долоо дахь өдөр нь бүрэн амрах **Амралтын өдөр [Шаббат]** буюу ариун цуглаан болой. Та нар ямар ч ажлыг бүү хий. Энэ нь амьдрах бүх газарт чинь **Эзэний Амралтын өдөр** юм. (Леви 23:3)

Энэхүү хууль зааврыг иудейчүүд чанд баримталж, хаа явсан газраа Табернакл буюу Асар барьж, Шаббат (Бямба гараг; еврей. *Shabbat*-шаббат; грек. *Sabbaton*-σάββατον; орос. Суббота) өдрийг тэмдэглэж, тэндээ өргөл тахил өргөдөг байжээ (Гэтлэл 26-27). Улмаар Израилын ард түмэн Ханаан нутагт [одоогийн Израил, Палестин] суурьшиж, хожим Соломон (Шиломо) хааны үед Иерусалимд сүмийн барилгыг барьснаар (1Хаад 5-8; 2 Шастир 5-7) тэрхүү асар болон сүмийн аль аль нь жүүдүүдийн цуглах үйлийн гол орон зай, магтаал дууллын гол танхим болжээ (1 Шастир 16; Езра 3:10-11).

Израил хожим өмнөдөд Иуда, умардад Израил хэмээн хоёр хуваагдаж, аль алин нь Ассири болон Вавилонд олзлогдон цөлөгдөж, Йерусалим хот сүмтэйгээ бүрмөсөн устгагдан, ард түмэн нь Вавилоны нутаг руу цөлөгдөөд тэндээ 70 жил амьдрах хугацаанд сүмгүй болсон ард түмэн өөр хоорондоо уулзацааж, Саббат өдрөө сахин цуглардаг байсан нь хожим синагог хэмээх цугларалтын газрын нэр болсон гэж эрдэмтэд үздэг. Иудейн синагогийн уламжлал нь Езрагийн үеэс буюу ХТӨ 500-аад оны үеэс эхэлсэн гэж хэлж болно. Хуучин гэрээний Нехемия 8:8 дээр Езра Торааг⁸ энгийн ард иргэдийн ойлгох хэмжээнд тайлбарлаж, номлох ажлыг эхлүүлсэн байдаг. Синагогийн цугларалт нь иудей хүний үйлдэх ёстай зан заншил болж, Амралтын өдөр буюу Шаббат өдөр бүр Бичвэр уншиж, тайлал, номлол сонсож, Бурханд магтаал, ерөөл өргөх шашны болон амьдралын чухал хэв маяг болсон ажээ.

Цөллөгт байсан иудейчүүд өөрийн нутагтаа буцаж ирээд Йерусалим хотын хэрэм цайз, мөн сүмийг сэргээн босгосон тухай түүх Езра, Нехемия номонд гардаг. Есүс Христийн амьдрал Йерусалимын сүмтэй салшгүй холбоотой бөгөөд төрөөд найм хоногтой байхад нь эцэг эх нь Есүсийг Йерусалимын сүмд авчирч “Эзэнд өргөх” ёс гүйцэтгэдэг (Лук 2:22-23) ба Тэрээр жил бүр Алгасал баяраар

⁷ *Машияах – еврей.* מֶשֶׁה - *Messiah – Аврагч Тослогдсон нэгэн.* Шинэ гэрээний грек орчуулга нь χριστός буюу *Христ.*

⁸ *Еврей Библийн эхний 5 номыг Тораа гэж хэлдэг.* Мөн грекээр үүнийг *Пентатух* (πεντάτευχος) буюу “таван судар/хуйлмал” гэж хэлнэ.

Йерусалимд ирж тэмдэглэдэг байсан. Есүс арван хоёр настайдаа сүмийн багш нарыг сонсож, мөн гайхалтай олон зүйлийг асуун сууж байсан тухай түүх ч бий (Лук 2:41-52). Хожим Тэр өөрийн шавь нартайгаа сүмд ч (Иохан 2:13-25), синагогт ч очдог байсан. Иудейчүүд сүмд өргөл тахил өргөх ёсоо үргэлжлүүллээ гээд синагогоор цугларах дэг жаягаа орхиогүй юм. Нутагтаа буцан ирсэн цагаас хойш даруй 400 гаруй жилийн дараа Есүс Христийн үед ч синагог оршсоор байсан.

Есүс Өөрийн өссөн хот Назарт ирж, занисан ёсоороо Амралтын өдөр синагогт орж, Бичвэрээс уншихаар бослоо. (Лук 4:16)

Есүсийг дахин амилж, дээш одсоны дараагаар ч Христийн шавь нар мөн синагогуудаар явж Израилын Машиях нь Есүс юм хэмээн тунхаглаж байжээ.

Ямар ч Иудей хүн, эсвэл ямар ч бүлэг иудейчүүд синагог байгуулах боломжтой бөгөөд энэ нь өөрийн гэр орны хэсгийг 10 буюу түүнээс дээш хүн багах боломжтой байдлаар зориуд тохижуулсан өрөө юм. Иудейчүүд өөрийн оршин байгаа хот тосгонд буй синагогт, хэрэв олон синагогтой газар бол өөрт хамгийн ойр байгаа синагогт, эсвэл өөрийн даган дуурайхыг хүсдэг раббигийн (багш) синагогт очно. Тухайн нутгийн бүх хүн синагогт очих тул олон синагог байх тусмаа хүртээмжтэй байжээ.

Харин тэд [Паул болон нөхөд] Пергээс гарч Писидийн Антиохт ирээд, Амралтын өдөр синагогт орж суув. (Үйлс 13:14)

Анхны Христийнхний цугларалт иудейчүүдийнхээс ялгагдаж, Бямба гарагт биш харин Ням гарагт болон хувирсан нь Есүс Христийн дахин амилалтай холбоотой гэж үздэг (Марк 16:1-2; Матай 28:1; Лук 24:1; Иохан 20:1). Есүс Христийг дээш Бурхан Эцэгтээ одсоны дараа тэд долоо хоногийн эхний өдөр буюу Ням гарагт цуглардаг болсон.

Намайг очиход цуглуулахгүйн тулд долоо хоног бурийн эхний өдөр хүн бүхэн бололцоогоороо цааш нь хийж хадгал. (1Коринт 16:2)

Долоо хоногийн эхний өдөр талх хувахаар хамтдаа цуглах үед Паул маргааш нь явахаар шийдсэн тул, тэдэнтэй ярилцаж шөнө дунд болтол яриагаа үргэлжлүүлжээ. (Үйлс 20:7)

Иудейчүүдийн хувьд Амралтын өдөр нь Бямба гараг бөгөөд харин долоо хоног Ням гарагаас эхэлдэг. Тиймээс дээр дурдагдаж буй долоо хоногийн эхний өдөр бол Ням гараг юм. Түүгээр ч зогсохгүй тэд Ням гарагийг Эзэний өдөр хэмээн нэрлэдэг байв.

Эзэний өдөр би Сүнс дотор байсан бөгөөд ард минь бүрээнийх мэт чанга дуу сонсогдож... (Илчлэл 1:10).

Амралтын өдөр байнга цугларахгүй байгаа асуудлын талаар элч Паул буруушаан бичсэн байдаг ба хамтдаа цугларахгүй байгаа нь хайр ба сайн үйлсийг бадраахад саад болоод зогсохгүй гэм нүгэл үйлдсэн хэрэг мэтээр хэлсэн үг ч байдаг.

Хайр болон сайн үйлсийг бадраахын төлөө нэг нэгнээ анхаарч, хамтран цуглахыг умартан зурсил болгосон зарим хүмүүсийг үл дагаж, харин нөгөө өдөр ойртож буйг харах тусмаа бие биенээ улам илүү зорижуулъя. Учир нь бид ... зоргоороо нүгэл үйлдсээр байвал нүглийн төлөөх тахил цаашид үлдэхгүй (Еврей 10:24-26).

Ромын Эзэнт Гүрний доторх нэгэн хотын захирагч Плини дэ Янгер (Pliny the Younger – ойр. МЭ 112) гэгч тухайн үеийн эзэн хаан Тражанд (Emperor Trajan) бичсэн захидалдаа ийн бичжээ:

Болзсон өдрөө, тэд уүр цайхаас өмнө уулзаж, Христийг Бурхан хэмээн түүнд магтууг дуулдаг (Bettenson & Maunder, 2011, p. 4).

Мөн I зууны сүүл, II зууны эхээр бичигдсэн *Дидакэ* – товчлол. Арван хоёр элчээр дамжуулан харьтанд⁹ заах Эзэний сургаал) -ийн 14 дүгээр бүлэгт

Эзэний өдөр бүр цугларч, талх хуваан, талархал өргөхдөө өргөл чинь цэвэр байхын тулд гэм нүглээ эхлээд гэмши (Milavec, 2003, pp. 34–35)

гэсэн байдаг.

Гэвч Ням гарагийн цуглааныг буруутган үздэг, синагогтой адил Бямба гарагт цуглардаг бүлгүүд, урсгал чиглэлүүд бий. Тэдгээр урсгал чиглэлүүдийн зарим нь Христийн шашны доторх сект (sect) боловч зарим нь культ буюу гаж урсгал байдаг. Хэдийгээр тэдгээр нь Бямба эсвэл Ням гарагт цугларах асуудлаараа өөр өөр бодолтой боловч долоо хоног бүр цугларч, литургэд оролцох асуудалд адилхан үзэл баримтлалтай юм.

Тэгэхлээр дээр дурдагдсан баримтууд Христийн шашны долоо хоног бүрийн цуглаан нь Бичвэрт [буюу теологийн] тавигдсан *шаардлага*, хэрэгцээ гэдгийг харуулж байна. Тиймээс Христийн шашны итгэгч нар долоо хоногийн нэг өдөр цуглардаг нь тэдний итгэл үнэмшлийн нэгэн тулгуур юм. Монгол улсад үйл ажиллагая явуулж буй Христийн шашны сүм, цуглааны тоо уламжлалт буддын шашныхаас илүү олон байгаагийн нэг гол шалтгаан бол энэ болой. Христийн шашны сүм, цуглааны хувьд итгэгчиддээ үйлчлэх хэлбэр, зан үйл нь Буддын шашныхаас эрс ялгаатай бөгөөд Христийн цуглааныг чиглүүлэн авч явахад теологийн боловсролтой цөөн тооны хүн хангалттай тул бүтэн цагаар ажиллах орон тооны олон ажилтан байх шаардлагагүй байдаг нь сүм хийдийн ажилтны тоо цөөн гэсэн статистик баримтыг илтгэж буй юм.

Дуулах зан үйлийн тухайд

Иудейн болон Христийн шашин өөрсдийн литургэд дууг авч ашигладгаараа төстэй юм. Энэ нь мөн л синагогийн зан үйлээс гаралтай. Христэч литург аялах, хөгжимдөх үйлдэлгүйгээр хийгдэх боломжтой¹⁰ боловч Христийн шашин эртнээс зан үйлдээ дууг хэрэглэж ирсэн уламжлалтай.

Дуулах нь еврей литургийн үүслийн үетэй, тухайлбал израйлчууд Миссиэрээс зугатан гарч, ялалт байгуулсантай холбоотой, (Гэтлэл 15:1-21) тэдний ялалтын дуу нь талархал, магтаалын дууны эхлэл болсон гэж судлаачид (Hill. 1996, pp 203-204) үздэг. Иудейчүүдийн “сүмийн дууны ном” гэгддэг Хуучин гэрээний Дуулал номын яруу найргийг Израйлийн түүхийн туршид олон зохиогч бичсэнээс талыг нь Давид хаан өөрөө зохиосон ажээ. Израилчууд шинэ сүмийн нээлтэд (Дуулал 30), Саббат сахихад (Дуулал 92), сүмийн мөргөлд (1Шастир 29:28; 30, Дуулал 100:2, Амос 8:3), тусгай баяр ёслолд (Исаиа 30:29) дууллаас дуулдаг байсан.

Судлаачид Дуулал номын дуунуудыг хэрэглээгээр нь 1) Магтуу, 2) хувьчилсан талархлын дуу, 3) хамт олны талархлын дуу, 4) хувьчилсан гашуудал, 5) хамт олны гашуудал, 6) найдварын дуу, 7) мэргэн ухаан, 8) дурсамж, 9) литург, 10) хааны дуу хэмээн 10 төрөлд хуваасан байдаг.

⁹ Харь үндэстэн (*foreigner, heathen, pagan*) гэх угийг Ариун Библид (2013) харьтан гэж хэрэглэснээр аваа.

¹⁰ Протестант зарим уламжлалд хөгжмийн зэмсэг болон дуулахыг буруушаадаг. Энэ нь литургийн утга учрыг уран сайхнаар давамгайлах, булин гартуулах, сатааруулах, сэтгэл хөдлөлийг ашиглах вий гэсэн сэрэмжлэлээс үүдэлтэй.

Вавилоны цөллөгөөс жүүдүүд чөлөөлөгдөн буцаж ирэхэд, тэдний дотор нийт эрэгтэй, эмэгтэй хоёр зуун сүмийн дуучид байсан гэж Езрад тэмдэглэжээ (Езра 2:65, 70). Хоёр дахь сүмийн шавгыг тавихад, мөн Йерусалимын хана хэрмийг босгосны баярыг хийхэд Дууллаас дуулж байжээ.

Тэд ЭЗЭНийг магтан талархал өргөж, -Тэрээр сайн сайхан бөгөөд Түүний энэрэл хайр Израиль дээр мөнхөд байдаг гэж дуулцгаав. ЭЗЭНий өргөөний суурь тавигдсан тул бүх хүн ЭЗЭНийг магтахдаа чанга дуугаар уухайлцгаав (Езра 3:11; үз. Нехемия 12:8, 27, 46).

Шинэ гэрээнд дуулах зан үйлийн талаар онцгойлон тушаасан үг байхгүй ч Хуучин гэрээний литүрг дэх дуулах зан үйл хэвээр хадгалагдан ирсэн байгааг Есүсийн үеийн түүхээс харж болно.

Магтуу дуулсны дараа тэд Чидун уул өөр явцгаав (Матай 26:30, үз. Марк14:26)

Чидун уулан дээрх энэхүү магтуу дууг Дуулал 113-118 -аас авсан байх магадлалтай, учир нь иудейчүүд Алгасал баяраар эдгээрийг хэрэглэдэг байжээ (McKinnon, 1987, р. 13). Дуулал 113-118 дууллуудыг Халлел буюу *Магтаалын* дууллууд гэж хэлдэг.

Библид *Бурханыг магтсан* гэх ойлголт нь ихэвчлэн дуулсан гэсэн утгыг агуулсан байдаг.

...Бурханыг магтаж, хамаг ардын хайр хүндэтгэлийг олж байв... (Үйлс 2:47).

Тиймд Түүгээр дамжуулан Бурханд магтаалын тахилыг үргэлж өргөцгөө... (Еврей 13:15).

Дөнгөж бүрэлдэн бий болсон Христитгэлийнхэн өөр хоорондоо магтуу, дуулал, сүнслэг дуунуудаар дуулж ярилцахыг, улмаар тэр замаар бие биенээ Бурханы үгээр зааж сургахыг элч Паулuri алжээ.

... Сүнсээр дүүр. Ингэхдээ дуулал, магтуу ба сүнслэг дуунуудаар өөр хоорондоо ярилцаж, Эзэнд хандаж зүрхэндээ дуулж, ая дуу зохиож... (Ефес 5:18-19).

Зүрхэндээ Бурханд хандсан баяртайгаар дуулах сүнслэг дуу, магтуу, дууллууд, бүхий л мэргэн ухаанаар та нар бие биендээ заан, бие биенээ сэнхрүүлэн Христийн үг та нарын дотор бялхам орших болтугай (Колоссай 3:16).

Ромын бишоп Клемент (Clement of Rome – ойр. ХТ 96) тухайн үеийн Коринт хотод нэгэн захидал бичиж [1Клемент гэж нэрлэдэг], тэнд хамтдаа цуглаад Санктуус¹¹-ыг Эвхаристын үед дуулах тухай дурдсан нь дуулах зан үйл I зууны төгсгөл гэхэд байсныг харуулдаг.

Үй түмэн ангелууд таны дэргэд зогсон түүний хүсэлд нийцүүлэн үйлчилж байгаа гэдгийг саная. Учир нь Бичвэр хэлэхдээ, “түм түмээрээ түүний дэргэд зогсож, мянга мянган удаа түүнд үйлчилж, хашхираан, “Ариун, ариун, ариун бол Саббатын Эзэн юм. Бүх бүтээл түүний алдраар дүүрэн” хэмээдэг. Тиймээс нэгэн сэтгэлээр цугларч, нэгэн дуу хоолойгоор түүн өөд чин зүрхнээсээ хашхирцааяа. Ингэснээр бид түүний агуу бөгөөд алдартай амлалтыг хуваалцах юм (Lake, 1998, р. 67).

¹¹ Энэ нь латинаар *Sanctus* буюу *Ариун* гэсэн утгатай үг. *Исаиа 6:3* дээр хэлсэнчлэн *Бурханыг “Ариун Ариун Ариун”* хэмээн гурвантаа магтан дуулсныг Санктуус хэмээн нэрлэж занисан.

Игнатиус (Ignatius of Antioch – ойр. 35-107) Ромд бичсэн захидалд өөрийнхөө баригдан цаазлуулах тухай бичихдээ дуу хөгжмийн метафор ашигласан байдаг.

Бурханы төлөө унахаас өөр зүйл бүү ирэг; тахилын ширээ энд байна. Ингэснээр Эцэг Бурханд Есүс Христийн дотор та бүхэн **найрал дууллах** болно, учир нь Сирийн бишопыг Бурхан наран мандахаас жаргах зүйт авчаачихыг зохицтой хэмээн үзжээ (Schoedel, Ignatius, & Koester, 1985b, p. 170).

II зууны дунд үед Жастин Мартир (ойр. ХТ 100-165 – Justin Martyr) Өчил (Apology) хэмээх бүтээлдээ эртний цусан тахил зэргийг үйлдэхийн оронд харин залбирал, талархлын магтууг өргөхөд хангальтай тухай дурджээ.

Зөвхөн дараах мөргөл нь Түүнд зохицтой гэж бид сурсан. Галаар шатаагдах тэдгээр зүйлс [тахил] бидний болон бусад хэрэгцээт хүмүүсийн төлөө хэрэглэгдэхээр түүгээр бүтээгдсэн юм. Тиймээс бид сүсэгт залбирал, **магтууг түүний бүтээл** болон эрүүл мэнд байлгахаар өгөгдсөн бүх зүйлийн төлөө талархалтайгаар өргөнө (Apology 1:13) (Richardson et al., 2006, p. 249)

1909 онд дөчин хоёр дуулал бүхий Соломоны Дуу (Odes¹² of Solomon – ойр. I зууны төгсгөл) хэмээх цуглуулгыг Ж. Рендел Харрис (J. Rendel Harris) олсон.¹³ Тэнд дуулах тухай эшлэлүүд их байдгийн нэг жишээ нь Оде 14:7-8 юм.

Үнэнийхээ дууг надад заагаач; таны дотор үр жимс би ургуульюу
Ариун Сүнснийхээ китарааг¹⁴ надад дэлгээч; **ноот бүрээр би таныг магтъюу**, өө Эзэн (Charlesworth, 2009, p. 40).

Дээр дурдсан Плинигийн захидалд мөн анхны итгэгчид Христийг Бурхан хэмээн итгэж, түүнд магтуу дуулдаг гэжээ.

Болзсон өдрөө, тэд үүр цайхаас өмнө уулзаж, Христийг бурхан хэмээн түүнд **магтууг дуулдаг** (Bettenson & Maunder, 2011, p. 4).

Египетийн Александр хотын Клемент (Clement of Alexandria - ойр. ХТ 150-215) өөрийн бичсэн Харийнханд өгөх Ятгалга (Protrepticus) гэдэг бүтээлдээ Есүс Христийг Шинэ Дуу хэмээн зүйрлэжээ.

Энэ бол **Шинэ Дуу**, эхнээс байсан бөгөөд эхнээс ч өмнө байсан Үгийн бидний дунд гэрэлтэх нотолгоо юм (Clement, 1999, p. 17)

Клементын ажлыг удаалан авч Александрын Катекатик Сургуулийн (Catechetical School of Alexandria) захирал болсон Ориген (Origen – ойр. ХТ 185-265) Целсусын эсрэг (Against Celsus эсвэл Contra Celsum) бүтээлдээ аливаа нар сар, хот улсыг магтан дуулахгүй, харин Бурханд магтаал өргөнө гэж хэлсэн байгаагаас тухайн үеийн Христийн шашны мөргөлийн дуулах зан үйл онцгойлон Бурханд зориулагдах ёстой гэсэн хатуу дүрэмтэйг харуулдаг.

Харин бид үүний эсрэгийг [Целсусын эсрэг] мэддэг. Бид цор ганц Бурханд болон түүний цорын ганц Хүү, Логост зориулан **талархлын магтууг дуулдаг** (VIII, 67) (Chadwick, 1980, p. 503).

¹² Odes гэдэг нь грек гаралтай дуу гэсэн уг.

¹³ Уг эх сурвалж нь Харрисын Египт болон Палестинаар (1888-89) аялах үедээ худалдан авсан 47 хүйлмэл дотор байсан бололтой. Тэрээр Одесыг грек хэл дээрх зарим баримтуудад харж байсан боловч энэ удаад бүтнээр нь сири хэл дээр олсон гэдэг.

¹⁴ Китара нь лир маягийн хөгжмийг заасан нэр. Үүнийг оричн үеийн гитар хөгжмийн эхлэл байсан гэж зарим эрдэмтэд үздэг. Грек. κιθάρα; Ром үсгээр *kithāra*; Латинаар *cithara* гэдэг.

Дурьдсан баримтуудаас үзэхэд дуулах нь Христийн шашнаас өмнө иудейн болон паган шашны зан үйлд байсан элемент байна. Христийн шашин үүсэж, бүрэлдэн тогтох явцад магтан дуулах зан үйл улам баяжиж, хожим Дундад Зууны үед хүчээ авчээ. Христийн шашны цуглаан дахь дуулах зан үйл Бурханд л зориулж өргөгдөх ёстой гэсэн ухагдахуун эндээс тод харагдаж байна. Нөгөөтэйгүүр Библийн Шинэ Гэрээнд ч бичигдэн сайшаагдсан, баялаг уламжлалтай байна.

Библид заавал дуулах ёстой гэсэн тушаал нэгэнт байхгүй тул Христийн шашны цуглааныг дуугүйгээр үйлдэж болох талтай боловч уламжилж ирсэн байдлаас нь харвал орчин үеийн сүм цуглаануудын хувьд дуулах зан үйл салшгүй нэгэн хэсэг болсныг өнөөгийн Монгол даяар үүсэн хөгжиж буй тэдний сүм чуулгануудын үйл ажиллагаа мөн илтгэж байна. Өнөөдөр дуу хуургүйгээр магтаал өрөөл өргөж буй цуглаан бараг байхгүй. Хөгжмийн зэмсэг, цахилгаан техник хэрэгсэл элбэг болсон өнөөгийн нөхцөлд хот суурин газруудын ихэнхи чуулганууд гитар, бөмбөр, цахилгаан төгөлдөр хуур зэргийг өргөнөөр хэрэглэж байна. Тэдний уламжлал нь Ази, хойд Африк, баруун Европын уулзвар газраас үүсэлтэй тул дуулах зан үйл нь ч, дууны төрөл жанр нь сонгох сонголтоор баялаг байгаа нь харагддаг.

Ашигласан материал

1. Ариун Библи. Ариун Бичээс Нийгэмлэг, 2013.
2. Bettenson, H., & Maunder, C. (Eds.). (2011). *Documents of the Christian church* (4th ed. / edited by Chris Maunder). Oxford ; New York: Oxford University Press.
3. Chadwick, H. (1980). *Origen: Contra Celsum*. Cambridge [Eng.] ; New York: Cambridge University Press.
4. Charlesworth, J. H. (Ed.). (2009). *The earliest Christian hymnbook: the Odes of Solomon*. Eugene, Or: Cascade Books.
5. Clement. (1999). *Exhortation to the Greeks. The rich man's salvation. To the newly baptized* (Reprinted; G. W. Butterworth, Trans.). Cambridge, Mass.: Harvard Univ. Press.
6. Dix, G. (1949). *The Shape of The Liturgy* (Fourth Impression). Glassgow, Great Britain: University Press.
7. Hill, A. E. (1996). *Enter His Courts with Praise! Old Testament Worship for the New Testament Church*. Grand Rapids, Mich: Baker Books.
8. Kroeker, C. Y. (2005). *Music In Christian Worship: At the Service of the Liturgy*. Collegeville, Minn: Liturgical Press.
9. Lake, K. (Ed.). (1998). *The Apostolic fathers: in two volumes. 1: Clement I. Clement II. Ignatius. Polycarp. Didache. Barnabas* (Reprinted). Cambridge, Mass.: Harvard Univ. Press.
10. McKinnon, J. W. (Ed.). (1987). *Music in early Christian literature*. Cambridge ; New York: Cambridge University Press.
11. Milavec, A. (Ed.). (2003). *The Didache: text, translation, analysis, and commentary*. Collegeville, Minn: Liturgical Press.
12. Richardson, C. C., Fairweather, E. R., Hardy, E. R., & Shepherd, M. H. (Eds.). (2006). *Early Christian Fathers*. Louisville London: Westminster John Knox Press.
13. Schoedel, W. R., Ignatius, & Koester, H. (1985a). *Ignatius of Antioch: a commentary*

- on the Letters of Ignatius of Antioch. Philadelphia: Fortress Press.
14. Schoedel, W. R., Ignatius, & Koester, H. (1985b). *Ignatius of Antioch: a commentary on the Letters of Ignatius of Antioch*. Philadelphia: Fortress Press.
15. White, James F. (1992) *Documents of Christian Worship: Descriptive and Interpretive Sources*. 1st edition. Louisville, Ky: Westminster John Knox Press.
16. <https://archive.org/details/odespsalmsofsolo00harruoft/page/66>
17. https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L20_3&year=2018, accessed April 21, 2019.

ABSTRACT

A statistical study shows that the number of Christian churches in Mongolia exceeds the number of traditional and other religious temples. Why is there such a difference in number? Why Christians in one place should be divided into many different gatherings to do their rituals? These are the questions we should explore. In this study, we explore the theological and traditional understanding of their weekly gathering, and its important element, the ritual of singing by looking into accounts in Christianity's main document, the Bible and the historical accounts of AD I-III centuries. It is evident that the reason Christianity gathers weekly to do their rituals is their theology and traditions. Thus, the fact that many Christian churches and organizations are established and do their rituals everywhere is an important part of expressing their faith. Further studies are needed to explore the worship, rituals, and gatherings of Christianity in Mongolia and the possible adjustments of governmental service according to their unique needs.